



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/434

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3 дахь заалт, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-ын /б/ заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 20, 21 дүгээр тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2016-2020 оны хөтөлбөрт тусгагдсаны дагуу Буянт, Булган, Мянгад сумдад хадлангийн механикжсан салаа байгуулах, газар тариалангийн тоног төхөөрөмж, трактор иж бүрдлийн /хадуур, тармуур, хаман боогч, чиргүүл, үрлэгч/ тээврийн хөлсөнд 22,000,000 төгрөг /хорин хоёр сая/-ийг “Газар тариалан” хөтөлбөрт тусгагдсан хөрөнгийн санхүүжилтээс гаргаж Хүнс, хөдөө аж ахуйн газрын дансанд шилжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал)-д зөвшөөрсүгэй.

2. Техник татан төвлөрүүлсэн тээврийн хөлсийг гэрээний дагуу холбогдох жолооч нарт 22,000,000 /хорин хоёр сая/ төгрөгийг тус тус гаргахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Г.Гончигсүрэн)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Ганданповрон)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б. ДҮГЭРЖАВ



02 02148